



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/41

Мандалговь


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5"а","в", 29.1.6"б","д", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.5, аймгийн Засаг даргын 2020 оны А/44 дүгээр захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дэлхий дахинд тархалт улам нэмэгдэж байгаа коронавирусээс урьдчилан сэргийлэх болзошгүй байдлын үед тусгаарлах байруудыг болон холбогдох албан тушаалтнуудыг бараа материалаар хангах арга хэмжээнд хөрөнгө зарцуулсугай.

2.Эрсдэлийн үед хэрэглэх хамгаалалтын хувцасны үнэ 700000 (Долоон зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөцийн зардлаас гаргахыг Тамгын газрын дарга (Б.Оюунчимэг), ня-бо (О.Бямбасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ